

**МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН ХОЛБООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН БУСАД ХУУЛИЙН
ТӨСЛҮҮДИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2019 оны 10 дугаар
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Ундармаа

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Эдийн засгийн байнгын хорооны 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Н.Учралаас 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцлээ.

Монгол Улсад бүртгэлтэй мэргэжлийн холбооны эрх зүйн байдал, үйл ажиллагааг Төрийн бус байгууллагын хуулиар зохицуулж байна. Уг хууль 1997 онд батлагдсанаас хойш 6 удаа өөрчлөлт орсон бөгөөд улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилтэй уялдуулан салбарын мэргэжлийн холбоодын үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэх, тогтвортой байдлыг хангах хууль, эрх зүйн орчинг сайжруулах шаардлага гарч байна.

Иймд хууль санаачлагч Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийг санаачилж, уг хуулиар мэргэжлийн холбоог оновчтой зохион байгуулалтад оруулж, мэргэшсэн гишүүдээс бүрдсэн, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх, үйлчилгээ үзүүлэх чадавхтай болгож, төрийн зарим чиг үүргийг шаардлага хангасан төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэхээр хуулийн төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг мэргэжлийн холбоод нь улс төр, бизнесийн бүлэглэлд үйлчилж байгааг цэгцлэх, Хууль зүйн байнгын хороотой хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллах, Улсын Их Хурлын гишүүн Д.Дамба-Очир мэргэжлийн холбоодод тавигдах шаардлагыг өндөрсгөх, Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар мэргэжлийн холбоод хөгжлийн эхэн үедээ шударга өрсөлдөөнийг хязгаарлаж, бизнесийн хөгжилд саад болж байсан бусад улс орнуудын гашуун сургамжийг анхаарч үзэх зэрэг саналыг гаргасан болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дээрх хуулийн төслийн үзэл баримтлалыг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл,

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Ж.ГАНБААТАР

